		<p>2.1.2.Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах, санал бодлоо солилцох, байгууллагын зүгээс хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааг сурталчлах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч буй эерэг, сөрөг мэдээлэлд тухай бүрт нь тайлбар, хариулт өгөх</p>		<p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд хүргэх ажлын хүрээнд МҮОНРТ-ийн “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлэгт 9 удаа, МҮОНРТ, Эх орон, 25 дугаар суваг, UBS, NTV, TV5, TV9, SBN, STAR, NBS, TM, Royal HD, ETV телевизүүдэд 40 удаагийн мэдээ, радиод 2, “Өнөөдөр”, “Зууны мэдээ”, “Өглөөний сонин”, “Үндэсний шуудан”, “Монголын үнэн”, “Монголын мэдээ”, “Засгийн газрын мэдээ”, “Улс төрийн тойм” сонинд 65 удаа, news.mn, eagle.mn, olloo.mn, zaluu.com, news.zone.mn, ugluu.mn, uls.mn, sorog.mn, grandnews.mn, tug.mn, undesten.mn, erennews.mn, unuudur.mn, news.mn.zindaa.mn, montsame.mn, infomongol.mn, itoim.mn, 24tsag.mn, polit.mn сайтуудад нийт 100 удаа тус тус мэдээ мэдээлэл өгч нийтлүүлсэн.</p> <p>Засгийн газрын 2011.01.25-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “ШШГБ-ын ажилтны өдөр”-ийг жил бүрийн 4 дэх долоо хоногт тэмдэглэн өнгөрүүлэхээр баталсан. Тус өдрийг тохиолдуулан ШШГЕГ-ын болон хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, салбар нэгжийнхээ бодлого чиглэл, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, шинэчлэн батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг сурталчлах ажлын хүрээнд харьяа хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, салбар нэгжүүд “Сүлд”, ТВ10, “Эрдэнэ”, “Мини Мандал”, “Мандал”, TBS, “GM”, “Соёмбо”, “Миний Монгол” телевиз, “Алтанговь”, “Булганы мэдээ” сонин зэрэг орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, баримтат кино, нэвтрүүлэг, танилцуулга, ярилцлага, мэдээ мэдээлэл бэлтгэн олон нийтэд хүргэсэн.</p> <p>Дундговь аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх алба аймгийн FM 107.5 радиогийн “Хуулийн цаг” ярилцлагын нэвтрүүлэгт оролцож, байгууллагатай холбоотой мэдээ мэдээллийг иргэдэд өгсөн.</p> <p>Дорноговь аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх алба аймгийн DBS, MNT-ийн “Хуулийн цаг” ярилцлагын нэвтрүүлэгт орж, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, цагдан хорих байрны үйл ажиллагааны талаар иргэдийн сонирхсон асуултад хариулт өгсөн. Мөн “Өнөөгийн Дорноговь” сонины 03 дугаар сарын 21-ний өдрийн дугаарт албаны холбогдох мэдээ мэдээллүүдийг нийтлүүлсэн.</p> <p>Орхон аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх алба-Хорих 437 дугаар анги аймгийн “Номин” телевизийн “Хотын аялал” нэвтрүүлэгт оролцож, байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд хүргэсэн.</p>

				<p>ХЗДХЯ-ны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах ажлын албанаас бэлтгэн олон нийтэд хүргэдэг нэвтрүүлэгт СМДӨАЭАХХГ-ын сэтгэл зүйч, ахлах дэслэгч Д.Хатанзориг оролцож, архины хамааралтай албадан эмчлэгдэж буй иргэдийн талаар холбогдох мэдээллийг өгч ажилласан.</p> <p>Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-423 дугаар нээлттэй, хаалттай хорих анги нь аймгийн анхны чөлөөт сэтгүүл болох "Өвөрхангайн өнгө" сэтгүүлтэй хамтран ажиллаж, тус сэтгүүлд байгууллагатаа хийгдэж буй бүтээн байгуулалтын ажил, хоригдлуудын гар урлалын бүтээлүүдийн талаар нийтэлж, иргэдээс захиалга авч ажилласан байна.</p> <p>421 дүгээр нээлттэй хорих анги нь "Хорихын үйлчилгээний нэгдсэн төв" Төрийн бус байгууллагатай хамтран 2017 оны 3 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд "Аавын аягатай эр хүн" сэдэвт өдөрлөгийг зохион байгуулж, тус арга хэмжээний мэдээг ETV телевизээр, ахмадын баярын өдрийг тохиолдуулан ахмад настан, бэлтгэл хурандаа Д.Бадамзулын хөдөлмөрийн алдрыг тэмдэглэж, тус арга хэмжээний мэдээг MNC телевизээр олон нийтэд тус тус хүргэсэн байна.</p> <p>Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга, хурандаа О.Хадбаатар 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдөр аймгийн ТВ10 телевизийн "Суръя, суралцъя" нэвтрүүлэгт оролцож, "Номун далай" ахлах сургуулийн сурагчдад мэргэжлээ хэрхэн зөв сонгох болон зөв хүн болж төлөвших талаар ярилцлага өгч, сурагчдын асуусан асуултад хариулт өгсөн байна.</p> <p>Хэнтий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-419 дүгээр нээлттэй хорих анги нь орон нутгийн "Өндөрхаан" телевизтэй хамтран ажиллах гэрээ байгуулж байгууллагынхаа үйл ажиллагааг сурталчлан ажиллаж байна.</p> <p>"Хэрэмт цамхаг" УТҮГ үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний талаарх мэдээллийг upedi.mn сайтад 4, "Зар мэдээ" сонинд 3 удаа тус тус нийтлүүлжээ.</p> <p><i>ШШГЕГ-ын харьяа хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжүүд</i> "Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль"-ийн хэрэгжилт, Хууль зүйн салбарын "Нээлттэй бодлого"-ын баримт бичгийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан.</p>
		2.1.3. Алба хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажлыг зохион байгуулах		<p>Албаны сахилга бат, сонор сэрэмжээ улам өндөржүүлэн, удирдлагаас өгсөн үүргийг шуурхай биелүүлэх, төрийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиулахад дотоодын хяналтыг чиглүүлэн, үр дүнг тооцон ажилласан.</p> <p>2017 онд 407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, 415 дугаар хаалттай хорих анги, 427 дугаар хаалттай хорих анги, 429 дүгээр хаалттай хорих анги-төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Баривчлах ял эдлүүлэх 431 дүгээр анги, Баривчлах төв, Завхан аймаг дахь ШГГ, Ховд аймаг дахь ШГГ-457 дугаар хаалттай хорих анги, Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албаны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээг тус тус хийж, дүнг ШШГЕГ-ын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, хугацаатай зөвлөмжийг хүргүүлэн хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллаа.</p>

7.	2.	<p>2. Төрийн үйлчилгээг иргэдэд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх;</p>	<p>2.2.1. Иргэний шийдвэр гүйцэтгэлийн бүртгэлийн системийг өргөтгөж, ашиглалтын хүчин чадлыг нэмэгдүүлж, төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх;</p>	<p>Шийдвэр гүйцэтгэх зарим ажиллагааг онлайн хэлбэрт шилжүүлэх чиглэлээр Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим сангаас хөрөнгийн мэдээлэл татан авах эрхийг тус газрын бүс хариуцсан ахлах мэргэжилтэн болон төв, орон нутгийн Шийдвэр гүйцэтгэх алба, хэсгийн 39 ахлах шийдвэр гүйцэтгэгчид 2017 оны 02 дугаар сард эрх олгож, мэдээллийг үйл ажиллагаанд ашиглаж байна.</p> <p>Видео хурлын тоног төхөөрөмжгүй Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Налайх, Хөтөл, Замын-Үүд дүүрэг нэгжүүдийн тоног төхөрөөмжийн зардлыг шийдвэрлэн, онлайнд холболт хийсэн цахим бүртгэлийн санд холбогдоогүй байсан Ховд аймгийн Булган сум дахь 99 дүгээр тойргийн шийдвэр гүйцэтгэгчийг системд холбох ажлыг гүйцэтгэн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн.</p>
			<p>2.2.2. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогч талуудад ажиллагааны тухай мэдээллийг онлайн хэлбэрээр өгч, мэдээллийг нээлттэй болгох ажлыг эхлүүлэх;</p>	<p>“Шийдвэр гүйцэтгэлийн бүртгэл хяналтын систем”-ийг шинэчлэх, алдааг засварлах чиглэлээр “Шинэ шийдэл” ХХК-тай гэрээ байгуулж, системийн програм хангамжийг боловсронгуй болгож, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Баянгол дүүрэг, Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албанд туршилтын бүртгэлийг эхлүүлж, шийдвэр гүйцэтгэгчдийн дунд сургалт, аргачиллаар хангах ажлыг гүйцэтгэсэн.</p>
			<p>2.2.3. Шүүхийн шийдвэрээр тогтоосон төлбөртэй эсэх лавлагаа, мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд олгох;</p>	<p>Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөртэй эсэх талаарх лавлагаа, мэдээллийг нийт 39457 ширхэг гаргаснаас хэвлэмэл хуудсаар 24990 иргэнд, 14467 хуулийн этгээдэд олгож, орон нутгийн шийдвэр гүйцэтгэх алба, хэсгүүдэд цахим шуудангаар 3703 иргэнд, 2701 хуулийн этгээдэд буюу нийт 6404 тодорхойлолт, лавлагааг тус тус олгож, төрийн эрх бүхий байгууллагуудтай мэдээлэл солилцох, хамтран ажиллах ажлын хүрээнд 165 ширхэг лавлагаа, мэдээллийг үнэ төлбөргүйгээр олгоод байна.</p> <p>Арилжааны банкуудаас цахим шуудангаар ирүүлсэн хүсэлтийн дагуу 16499 лавлагааг холбогдох баримттай тулгаж, мэдээлэл хүргүүлсэн.</p> <p>Төв, орон нутгийн Шийдвэр гүйцэтгэх алба, хэсгийн хүсэлтийг үндэслэн 7688 тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг түдгэлзүүлж, 3076 тээврийн хэрэгслийн эрх сэргээх ажиллагааг явуулж, тээврийн хэрэгслийн өмчлөлийн талаар 7013 лавлагаа буюу нийт 17777 мэдээллийг харьяа нэгжүүдэд хүргүүлэн ажилласан.</p> <p>Төрийн үйлчилгээг шуурхай хүргэх зорилгоор Дүнжингарав худалдааны төвийн байранд байрлах “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-д шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр төлбөргүй талаарх лавлагааг нийт 999 иргэн, хуулийн этгээдэд 1115 буюу нийт 2114 лавлагааг олгож ажилласан.</p>

8.	3.	3. Төрийн үйлчилгэний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, Албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах	<p>2.3.1. ШШГЕГ-ын үйл ажиллагаанд “Хэрэглэгчийн үнэлгээ” хийлгэх ажлыг зохион байгуулах</p> <p>2.3.2. Хамтран ажилладаг байгууллага, албан тушаалтан, иргэдээс хэрэглэгчийн үнэлгээний талаарх судалгааг авч, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх ажиллах</p>	<p>Хууль зүй, дотоод хэргийн яамны захилгаар “Жи Би Эм” судалгаа, шинжилгээний байгууллага нь 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн хооронд ШШГБ-ын харьяа Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, 429-р хаалттай хорих анги-Нэгдсэн төрөлжсөн эмнэлэг, 401-р хаалттай хорих анги- Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаанд “Хэрэглэгчийн үнэлгээ” хийсэн ба ерөнхий үнэлгээгээр 93.9 хувь буюу 4.7 оноотой үнэлэгдсэн.</p> <p>Тус судалгааны байгууллагаас 9 асуудал бүхий зөвлөмжийг гаргасан бөгөөд цаашид байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэн хуулиар олгогдсон хүний эрхийг хангах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн хэрэглээг иргэдэд хүргэх ажлыг сайжруулахаар ажиллаж байна.</p>
			<p>2.4.1. ШШГБ-ын цахим хаягаар өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэлтэд хяналт тавьж, судлан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх</p> <p>2.4.2. Иргэний гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах албан тушаалтны нэр, харилцах утас, иргэний хүлээн авах уулзах цагийн хуваарийг цахим хуудаст тухай бүр шинэчлэн байршуулах</p> <p>2.4.3. Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар цахим хуудсаар мэдээлэх</p>	
<p><i>Гурав. "Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах" арга хэмжээний хүрээнд:</i></p>				
10.	1.	1. Улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх	3.1.1. Төсөв, санхүүгийн үйл ажиллагаа ил тод, нээлттэй ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих нөхцөлөөр хангах ажлыг зохион байгуулж, хяналт тавих	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, харьяа байгууллага бүр шилэн самбарт санхүүгийн үйл ажиллагааны холбогдох мэдээллийг тухай бүр байршуулж, олон нийтэд мэдээлэл нээлттэй, ойлгомжтой, хяналт тавих боломжит нөхцөлөөр хангасан. Мөн улсын төсвийн удирдлагын тогтолцоог сайжруулах зорилгоор төсвийн төлөвлөлтийн програмыг шинээр нэвтрүүлж, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байна.

11.	2.	2. Тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх	3.1.2. Тендерийн шалгаруулалтыг ил тод, нээлттэй зохион байгуулж, сонгон шалгаруулах	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендерийн шалгаруулалтыг ил тод, нээлттэй зохион байгуулж, сонгон шалгаруулсан ба тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх бэлтгэл ажил хангагдсан
<i>Дөрөв. “Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын үүдэргэ, ил тод, хараат бус байдлыг бүхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах зорилтыг хангах” арга хэмжээний хүрээнд:</i>				
			<p>4.1.1. ШШГБ-ын алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах</p> <p>4.1.2. Сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлон мэргэшүүлэх сургалтад алба хаагчдыг хамруулах</p>	

			<p>хууль болон эрх зүйн актууд зэрэг сэдвээр төв, орон нутгийн болон төрийн байгууллагуудын алба хаагчдаар хичээл, сургалтыг зохион байгуулжээ. Тухайлбал 2017 онд шинээр батлагдсан хууль болон бусад эрх зүйн актуудаар Хорих 401, 405, 407, 411, 413, 415, 419, 421, 425, 429, 431, 435, 439, 443, 445, Цагдан хорих 461, Өвөрхангай, Сэлэнгэ, Сүхбаатар, Баян-Өлгий аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх алба, Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Шийдвэр гүйцэтгэлийн хэсэгт тус тус сургалт зохион байгуулсан.</p> <p>Хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, салбар нэгж нь 2017 онд сургалтын үйл ажиллагаандаа өндөр ач холбогдол өгч шинэ санал санаачилга гарган төрийн болон төрийн бус, сургалтын байгууллагатай хамтрах, алба хаагчдын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх хүрээнд бодитой арга хэмжээ авч ажилласан нь урьд өмнөх онуудтай харьцуулахад нэмэгдэхүйц байна.</p> <p>2. ШШГБ-д ажиллаж буй төрөл мэргэжлийн санхүү, эмч, эмнэлгийн ажилтан, гүйцэтгэх ажил, харуул хамгаалалт, шийдвэр гүйцэтгэгч, инженер, холбооны техникч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, хүний нөөц, сургалт, тоо бүртгэлийн ажилтны мэргэшлийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор харьяа газар, хэлтэстэй хамтран жил бүр мэргэшүүлэх сургалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт төвлөрүүлэн зохион байгуулсан.</p> <p>“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн аюулгүй байдлыг хангах мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт”-ын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/54 дүгээр тушаалаар батлуулан төвлөрсөн хорих ангиудад 2017 оны 03 дугаар сарын 15-аас 07 дугаар сарын 04-ний хооронд сургалт зохион байгуулсан.</p> <p>Хорих анги, шийдвэр гүйцэтгэх газар, салбар нэгжид шинээр томилогдон ажиллаж буй алба хаагчдад цэргийн хэргийн мэдлэг олгох давтан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/205 дугаар тушаалаар батлуулж, 2017 оны 10 дугаар сарын 10-12-ны өдрийг хүртэлх хугацаанд 2 багц цагийн түргэвчилсэн сургалтыг амжилттай зохион байгуулсан. Тус сургалтад 45 алба хаагч хамрагдсан.</p> <p>Байгууллагын алба хаагчдын цэрэгжилч, жагсаалч байдлыг дээшлүүлэх, жагсаалын дүрмийг биечлэн гүйцэтгэх дадал чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын цэргийн хэргийн мэдлэг, цэрэгжилч, жагсаалч байдлыг сайжруулах аян”-ы удирдамжийг боловсруулан батлуулж, 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсан.</p> <p>Хорих байгууллагад нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсч, онцгой нөхцөл байдлын үед Үндэсний аюулгүй байдлыг хангах Төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор 2017 оны 11 дүгээр сарын 08-09-ний өдрүүдэд Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх</p>
--	--	--	--

			<p>газар-437 дугаар хаалттай хорих ангийн байршилд Команд штабын сургалт зохион байгуулсан ба 130 алба хаагч хамрагдсан.</p> <p>Мөн газар зүйн байршлаас хамааран бүсчилсэн болон зайн хэлбэрээр мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж байна. Үүнд:</p> <p>Төвлөрсөн сургалт:</p> <ul style="list-style-type: none"> - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төв, орон нутгийн удирдах ажилтны нэгдсэн зөвлөгөөнийг 2017 оны 01 дүгээр сарын 18-20-ны өдрүүдэд зохион байгуулсан. Зөвлөгөөнд нийт 96 удирдах албан тушаалтан хамрагдсан. - Хүний нөөц, сургалт, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн, архив, бичиг хэргийн эрхлэгч нарын мэргэшүүлэх сургалтыг 2017 оны 03 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд зохион байгуулсан ба сургалтад нийт 68 алба хаагч хамрагдсан. - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А/197 дугаар тушаалаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын Сургалт, хүний нөөц, хэвлэл мэдээлэл, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, архив бичиг хэргийн эрхлэгч нарт зориулсан мэргэшүүлэх сургалтыг 2017 оны 09 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд зохион байгуулсан. Тус сургалтад 60 алба хаагч хамрагдсан. - Хорих ял эдлүүлэх албаны болон хотын бүсийн хорих ангийн нийгмийн ажилтнуудыг чадваржуулах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Хууль сахиулахын их сургууль, АНУ-ын “Юта их сургууль”-ийн Нийгмийн ажлын сургуулийн профессор Жерри Буйе бусад төлөөлөгчдийн хамтарсан уулзалт, сургалтыг 2017 оны 10 дугаар сарын 09-ний өдөр ХСИС дээр зохион байгуулсан. - Хорих анги, байгууллагын нийгмийн ажилтан, эмч, төлөөлөгч нарын дунд хорих анги дахь сүрьеэгийн тусламж үйлчилгээ, халдвар хяналтыг зохион байгуулах сэдвээр нэгдсэн сургалтыг 2017 оны 09 дүгээр 28, 29-ний өдрүүдэд зохион байгуулж нийт 65 алба хаагчдыг хамрууллаа. - 2017 оны 10 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эмч, эмнэлгийн ажилтнуудад зориулсан 2 кредит олгох сургалтыг 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэгт зохион байгуулсан бөгөөд тус сургалтад 51 алба хаагч хамрагдсан. <p>Бүсчилсэн сургалт</p> <ul style="list-style-type: none"> - Хотын бүсийн хорих анги, нэгжийн дарга нарт зориулсан мэргэшүүлэх сургалтыг 2017 оны 4 дүгээр сарын 17,18-ны өдрүүдэд зохион байгуулсан ба сургалтад нийт 17 удирдах албан тушаалтан хамрагдсан. - 2017 оны 4, 5 дугаар сард нийт 26 Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Төв, Дархан, Сэлэнгэ, Хөтөл, Мандал сум дахь Шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хэсгийн 48 ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгчдэд зайн сургалт зохион байгуулсан. - Санхүүгийн алба хаагчдын мэргэшүүлэх сургалтыг 2017 оны 5 дугаар сарын 08-21-ний өдрүүдэд зохион байгуулсан ба сургалтад нийт 205 алба хаагч хамрагдсан.
--	--	--	---

				<ul style="list-style-type: none"> - Шийдвэр гүйцэтгэгчдийн мэргэшүүлэх сургалтыг 2017 оны 5 дугаар сард зүүн болон хангайн бүсийн Шийдвэр гүйцэтгэх газар, хэсгийн алба хаагчдад зохион байгуулсан. Сургалтад нийт 42 алба хаагч хамрагдсан. - Хотын бүсийн хорих анги, нэгжийн дэд дарга, төлөөлөгч нарт “Аюулгүй байдал ба хорих байгууллага” сэдэвт сургалтыг 2017 оны 05 дугаар сарын 25,26-ны өдрүүдэд зохион байгуулсан ба сургалтад 18 алба хаагч хамрагдсан. - Хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, салбар нэгжийн алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх сургалтыг 2017 оны 3 дугаар сарын 10-ны өдрөөс 7 дугаар сарын 04-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсан ба сургалтад 1200 орчим алба хаагч хамрагдсан. <p>Зайн сургалт</p> <ul style="list-style-type: none"> - Хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дэд дарга, хуяглан хүргэх офицеруудын дунд ялтны хуяглан хүргэх зааврын хэрэгжилт, ШШГБ-ын тусгай тоногдсон автомашины стандарт, ерөнхий шаардлага, байршил тогтоогч төхөөрөмжийн талаарх ойлголт, суурилуулах заавар зэрэг сэдвээр 2017 оны 6 дугаар сарын 02-ны өдөр цахим сургалтыг зохион байгуулсан. - Шинэчлэн батлагдсан эрүүгийн хуулийн талаарх видео сургалтыг хорих анги, байгууллагын тоо бүртгэлийн ажилтнуудын дунд 2017 оны 6 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан. - Нийслэлийн Прокурорын газрын Зөрчлийн хэрэг бүртгэх хэлтэстэй хамтран Зөрчлийн тухай хуулийн 6.20, 15.2, 15.27 дугаар заалтын хэрэгжилтийг хангах чиглэлээр орон нутгийн ахлах болон шийдвэр гүйцэтгэгч нарт нийслэл дэх нэгжийн нийт 187 алба хаагчийг оролцуулан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны чиглэлээр 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдөр онлайн зайн сургалт зохион байгуулсан.
13.	2.	2.Хууль сахиулах байгууллагын алба хаагчийн давтан сургалтын хөтөлбөрийн агуулгад авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэх асуудлыг тусгаж, хэрэгжүүлэх	4.2.1.ШШГБ-ын алба хаагчдад 2017 онд зохион байгуулах албаны сургалтын хөтөлбөрт тусгагдсаны дагуу авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг үр дүнтэй зохион байгуулах	<p>Алба хаагчдад 2017 онд зохион байгуулах албаны болон мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг офицер, ахлагч, шийдвэр гүйцэтгэгч гэсэн ялгамжтайгаар 11 бүлэг сэдвийн хүрээнд боловсруулсан. Тус сургалтын хөтөлбөрт “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдвийг алба хаагчид гэмт халдлага, эрсдлээс өөрийгөө хамгаалх арга тактик, авлигаас урьдчилан сэргийлэх, түүнээс ангид байх, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эмийн хор уршиг түүний сөрөг нөлөө, архи дан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бөглөх зааварчилгаа зэрэг 5 дэд сэдвийн хүрээнд 5 цаг лекц, 1 цагийн семинар, нийт 6 цагийн сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Дээрх сургалтаар алба хаагчдын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэгийг нэмэгдүүлж, алба хаагчид аливаа гэмт халдлага, эрсдлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, чадварыг эзэмшүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эмийн эсрэг мэдээлэл, мэдлэгтэй болсон байна.</p>

14.	3.	3. Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах үүрэг бүхий албан тушаалтны хүрээг оновчтой тогтоож, мөрдөх	<p>4.3.1. Албан хаагчдын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулан цахимд баталгаажуулах</p> <p>4.3.2. Албан хаагчдын мэдүүлсэн хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэгт хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах</p> <p>4.3.3. Шинээр томилогдсон болон их хэмжээний өөрчлөлт орсон албан хаагчаас тухай бүр мэдүүлгийг гаргуулан авч, цахим санд оруулах, түүнд хяналт тавих</p>	<p>2016 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа улсын хэмжээнд 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрүүдэд явагдахад ШШГБ-ын хэмжээнд хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах нэр бүхий 615 албан хаагчаас мэдүүлгийг хуулийн хугацаанд 100 хувийн бүрдүүлэлттэй хуулийн хугацаанд гаргуулан авч, цахимд баталгаажуулсан.</p> <p>2017 онд шинээр болон шилжин, дэвшин томилогдохоор нэр дэвшсэн 153 албан хаагч, иргэний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-т хянуулахаар хүргүүлж, томилогдсон нэр бүхий 202, их хэмжээний өөрчлөлт мэдүүлсэн 13 нийт 830 албан хаагчаас хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулан авч ажилласан.</p> <p>Мэдүүлгийн бүрдүүлэлтийн хугацаанд мэдүүлэг гаргагчид тухай бүр хөрөнгө, орлогын мэдүүлэх талаар зөвлөгөө, мэдээлэл өгч, зөрчлийг тухай залруулан ажилласан.</p>
<i>Тав." Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн идэвх санаачилгыг дэмжих, зорилтыг хангах" арга хэмжээний хүрээнд:</i>				
			<p>5.1.1. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Авлигатай тэмцэх газраас тараагдсан материал, гарын авлагыг иргэдэд чөлөөтэй авах орчныг бүрдүүлэх</p> <p>5.1.2. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль, түүнд нийцүүлэн гаргасан журам, дүрэм, зааврыг албан хаагчдад танилцуулах</p>	<p>Авлигатай тэмцэх газраас тараагдсан гарын авлага, зурагт хуудсыг ШШГЕГ болон харьяа Хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс салбар нэгжүүдэд хүргүүлж, албан хаагч, иргэдийн үйлчлүүлэх хөдөлгөөнт цэг буюу "Нэг цонхны үйлчилгээний төв"-д байршуулж, иргэдэд мэдээлэл авах орчныг бүрдүүлэн ажилласан.</p> <p>УИХ-аас батлагдсан Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг Хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс салбар нэгжүүдэд хүргүүлж, албан хаагч, иргэдэд нээлттэй байдлаар байгууллагын цахим хаягт байршуулж, албан хаагч болон иргэдэд Авлигатай холбоотой 8 удаагийн инфографик мэдээллийг байршуулсан.</p> <p>2017 онд АТГ-тай хамтран орон нутаг дах хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, салбар нэгжүүдийн эрх бүхий албан тушаалтан, мэдүүлэг гаргах үүрэг бүхий албан тушаалтнуудад онлайн сургалтыг бүсчилсэн хэлбэрээр 2 удаа, ШШГЕГ-ын алба хаагчид болон хотын бүсийн хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, салбар нэгжийн эрх бүхий албан тушаалтнуудад ХАСХОМ-ийн цахим бүрдүүлэлтийн талаар, ШШГБ-ын "Удирдах ажилтны нэгдсэн зөвлөгөөн"-д ШШГЕГ болон төв, орон нутгийн анги, албадын дарга нарт удирдах ажилтны зүгээс авлигаас урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал зэрэг 4 удаагийн сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Мөн Ховд, Баян-Өлгий, Увс аймаг дахь шийдвэр гүйцэтгэх албадын ХАСХОМ гаргах үүрэг бүхий албан хаагчид болон эрх бүхий албан тушаалтнуудад цахим бүрдүүлэлт, хэрэглээ ХАСХОМ гаргахад анхаарах асуудлын талаар мэдээлэл хийж, Авлигатай тэмцэх газраас тараагдсан гарын авлага, зурагт хуудсыг олгосон.</p>

				АТГ-ын 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 01/7072 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвлөмж, 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 01/9240 дугаар албан бичгээр ирүүлсэн оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрийг жагсаалтыг ШШГЕГ-ын харьяа алба, газар, хэлтэс салбар нэгжид албан бичгээр хүргүүлж, биелэлтийг ханган ажиллах талаар үүрэг өгсөн.
--	--	--	--	---

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР